



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/179

Ховд

Байгаль орчны цэвэрлэгээ, сэг зэм устгал,
халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/40 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчин дэгдэхээс урьдчилан сэргийлэх, байгаль орчны бохирдлыг цэвэрлэх зорилгоор өвөлжилт, хаваржилтын хүндрэлийн улмаас бэлчээр, өвөлжөө, хаваржаа, нуур гол, булаг шанд, төв, орон нутгийн чанартай авто зам дагуу хорогдсон малын хүүр, сэг зэмийг цуглуулж төвлөрсөн устгалын цэгт булшилж устгах, малчдын өвөлжөө, хаваржааны хашаа хороо, өтөг бууцыг халдваргүйтгэх ажлыг 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Энэ ажилд сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, байгаль хамгаалагч, багийн Засаг дарга нар, Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасаг, малчид, иргэдийг дайчлан татан оролцуулж, баг бүрд сэг зэм булшлах цэг байгуулж, шаардагдах зардлыг санхүүжүүлэн зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Сэг зэм устгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлага, зөвлөмж, заавраар хангаж, Малын эмч мэргэжилтнүүдэд шаардлагатай халдваргүйжүүлэлтийн бодис, хувцас хэрэглэгдэхүүнийг олгож, хамтран зохион байгуулахыг Мал эмнэлгийн газрын дарга (Д.Батцэнгэл)-д үүрэг болгосугай.

4. Орчны цэвэрлэгээ хийх, мал амьтны сэг зэм, хог хаягдлыг устгах ажилд хүн хүчний дэмжлэг үзүүлж, хяналт тавьж хамтарч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Л.Батбаяр), Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (О.Хүрэлбаатар) нарт үүрэг болгосугай.

8400001 0430
Zah A/179 Ba

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Х.БАТБОЛД